



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 5/1042

Улаанбаатар хот

### Б.Амарбаясгаланг ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1, 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.10 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны “Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/63 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Их Хурлаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдаж, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны “Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/63 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Үйлчилгээ, аж ахуйн албаны орон тоог шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Үйлчилгээ, аж ахуйн албанд жолоочоор томилогдон ажиллаж байгаа Бэгзсүрэнгийн Амарбаясгаланг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. А.Амарбаясгаланд хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмж болох зургаан сарын үндсэн цалин 3.417.510 /гурван сая дөрвөн зуун арван долоон мянга таван зуун арван/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Долгорсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа А.Амарбаясгалантай холбогдох тооцоог зохих журмын дагуу хийж, хөдөлмөрийн гэрээг цуцлахыг Үйлчилгээ, аж ахуйн алба (Ц.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Р.ОТГОНЖАРГАЛ

1439501 3586